



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020. 02. 13 № 508

танай _____ -ны № _____ -т

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт 7

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Баяндун сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Баяндун сумын Монгол ардын нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Баяндун сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

“Баяндун сумын Монгол ардын нам”-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцоо ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцэн байна.

“Баяндун сумын Монгол ардын нам”-ын мөрийн хөтөлбөр /..... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Дорнод аймгийн сонгуулийн хороонд

Хавсралт хуудастай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

БОЛОРТУУЛ



011020565


Дорнод аймгийн Баяндун сумны
Монгол Ардын Намын хорооны
2020 оны 06 дугаар сарын ¹⁰₀₁-ны өдрийн
⁰¹₀₁ р хуралдааны ⁰¹₀₁ тоот тогтоолын хавсралт



**ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ
2020 ОНЫ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

БАЯНДУН СУМ

БАЯНДУН СУМ



1. Нийгмийн салбарт

- 1.1 Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл хүсэлтийг шуурхай шийдэж, тушаал, шийдвэр, үүрэг даалгаварын биелэлтийг хянадаг болно
- 1.2 Засаг даргын Тамгын газрын барилга засварлах
- 1.3 Сумын төвийн цахилгаан дамжуулах агаарын шугамыг шат дараалалтайгаар шинэчилнэ, өргөтгөнө.
- 1.4 Төрийн албан хаагч, багш ажилчдын нийгмийн баталгааг дэмжих.
- 1.5 Сумын төвийн гудамж талбайг камержуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлыг эрчимжүүлнэ.
- 1.6 Хүүхдийн тоглоомын талбайг нэмэгдүүлэх, орчны стандартыг мөрдүүлж, хүүхэд аюулгүй орчин бүрдүүлж, хяналтыг сайжруулна.
- 1.7 Сумын төвийн хорооллуудын гудамжны гадна гэрэлтүүлгийг үе шаттайгаар гэрэлтүүлэх
- 1.8 Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, тэдний үйл ажиллагааг бодлогоор дэмжих

2. Эрүүл мэндийн салбарт

- 2.1 Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлж, өвчнөөс урьдчилан сэргийлэх зан үйлийг төлөвшүүлэх, бодлогыг дэмжиж ажиллана.
- 2.2 Ахмад настан, хүүхдийг эмчлүүлэх таатай орчин нөхцлийг бүрдүүлэхийн зэрэгцээ хүн эмнэлгийг түшиглэн суурь өвчтэй хүүхдийг сувилан эрүүлжүүлэх сувилал тогтмол ажиллуулна.
- 2.3 Эрүүл шүд-эрүүл хүүхэд хөтөлбөрийг дэмжин ажиллах.
- 2.4 Эрүүл мэндийн төвийг засварлана.

3. Боловсрол, Соёл урлаг, Спорт

- 3.1 Сургалтын орчныг сайжруулах зорилгоор дотор их засвар
- 3.2 Соёл урлагийн салбарын хөгжлийг дэмжих, өв соёл, сумын дэд хөтөлбөрийг дэмжин ажиллах
- 3.3 Орон нутгийн судлах танхимыг шинээр барина.
- 3.4 Орон нутгийн номын сангийн уламжлалт үйлчилгээг чанаржуулах, номын баяжилт хийх
- 3.5 Залуучуудын чөлөөт цаг өнгөрүүлэх төвийг байгуулна.
- 3.6 200 хүүхдийн Бага сургууль, урлагийн заал барина.

4. Хөдөө аж ахуй

- 4.1 Бүх багуудад ундны усны худаг гаргах, малчдын санал, хүсэлт, иргэдийн оролцоонд тулгуурлан гүний худгуудыг гаргах, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх.
- 4.2 Малжуулах төсөл хэрэгжүүлэх /Хөдөөгийн багийн малчид/

4.3 "Органик" хөдөө аж ахуйг хөгжүүлэх төмс хүнсний ногоны тариалалтыг нэмэгдүүлэх, Сумын төвийн өрхүүдийг бодлогоор дэмжиж хүлэмжийн аж ахуй байгуулах

4.4 Малын үүлдвэр угсааг сайжруулах, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх үйл ажиллагааг бодлогоор дэмжин хөгжүүлэх

4.5 Мал эрүүлжүүлэх, мал эмнэлгийн үйл ажиллагааг сайжруулах

4.6 Арьс, шир, дайвар бүтээгдэхүүн боловсруулах цех байгуулна.

4.7 Мах, ногоо хадгалах зоорь байгуулна.

4.8 Сумын тариаланд тохиромжтой атар болон атаршсан талбайг эргэлтэнд оруулна.

5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

5.1 Жижиг дунд үйлдэрийг чиглэлээр Сум хөгжлийн сангийн хөрөнгийг орон нутгийн онцлогт тохируулан, иргэдэд тэгш хүртээх, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

5.2 Хүн, амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин орлогыг тогтвортой нэмэгдүүлж, жижиг дунд бизнесыг өрх, гэр бүлд нэмэгдүүлэх бодлогыг дэмжинэ.

6. Байгаль орчин

6.1 Байгаль орчны багц хуулийг хэрэгжүүлэх цогц арга хэмжээ авч, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтүй үйлдвэрлэл, үйлчилгээ болон байгалийн нөөцийн хууль бус ашиглалтанд тавих хяналтыг сайжруулна.

6.2 Уул уурхайн олборлолтын нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийлгүүлнэ.

6.3 Гол, горхи булаг, шанд, рашааны ундаргын эхийг хамгаалах ажлыг эрчимжүүлнэ.

**БАЯНДУН СУМЫН МОНГОЛ АРДЫН
НАМЫН ХОРОО**